

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/04-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ж.Цогт Утас: 7036-3036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13-14
4. Аудитын тайлан	14-17
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17-18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН
ДАРГА Н.ЭРДЭНЭБАТ ТАНАА

2024.02.16 № СЭА-2024/04-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус төв нь 156,119.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж /автоклав – эмнэлгийн хог хаягдал устгах/-ийг ЭМЯ-наас үнэ төлбөргүйгээр хүлээн авснаас санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн хөрөнгийн дүн өссөн байна.

Аудитын гол асуудал

Ковид 19 цар тахал өвчинтэй холбоотойгоор өмнөх онуудад ЭМЯ, аймгийн ЭМГ-аас үнэ төлбөргүй шилжүүлсэн болон байгууллагын төсвийн хөрөнгөөр худалдан авсан нийт 101,086.9 мянган төгрөгийн 40,580 ширхэг нэг удаагийн хамгаалах хэрэгсэл /био аюулгүйн сав, бээлий, маск, нүдний шил, аюулгүйн хайрцаг, комбинезон, хормогч/ нь тус төвийн бараа материалын дансанд бүртгэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 3 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	144,606,635.50	122,328,643.50
35	БАРАА МАТЕРИАЛ	144,606,635.50	122,328,643.50
351	Түүхий эд материал	120,530,781.00	103,061,089.00
35130	Эм боох материал	120,530,781.00	103,061,089.00
354	Хангамжийн материал	24,075,854.50	19,267,554.50
35410	Бичиг хэргийн материал	269,750.00	226,150.00
35420	Аж ахуйн материал	22,206,104.50	18,141,404.50
35440	Түлш, шатах тослох материал	1,600,000.00	900,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	306,676,282.62	438,578,033.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	306,676,282.62	438,578,033.70
392	Биет хөрөнгө	289,928,045.88	421,931,476.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	251,798,553.43	251,798,553.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	(31,686,136.63)	(40,254,937.51)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	80,735,000.00	80,735,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(59,890,000.09)	(67,470,000.13)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	161,932,480.45	318,052,058.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(119,227,016.62)	(126,176,411.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,605,090.00	34,605,090.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,498,964.56)	(30,415,394.14)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,522,825.92	1,522,825.92
39215	Хуримтлагдсан элэгдэл	(363,786.02)	(465,307.70)
393	Биет бус хөрөнгө	16,748,236.74	16,646,556.78
39301	Программ хангамж	1,372,400.00	1,372,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,064,163.26)	(1,165,843.22)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,440,000.00	16,440,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	451,282,918.12	560,906,677.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	451,282,918.12	560,906,677.20
51	Засгийн газрын хувь оролцоо	451,282,918.12	560,906,677.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	214,786,273.00	214,786,273.00
51101	Өмч: - төрийн	214,786,273.00	214,786,273.00
512	Хуримтлагдсан үр дүн	20,224,907.43	129,848,666.51
51210	Өмнөх үеийн үр дүн	(119,933,838.18)	20,224,907.43
51220	Тайлант үеийн үр дүн	140,158,745.61	109,623,759.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	216,271,737.69	216,271,737.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	451,282,918.12	560,906,677.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	569,686,026.00	529,828,478.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	133,531,726.00	156,617,078.10
120	Нийтлэг татварын бус орлого	133,531,726.00	156,617,078.10
1201	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	11,770,000.00	156,119,578.10
1202	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	121,761,726.00	497,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	436,154,300.00	373,211,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	430,801,100.00	361,045,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	430,801,100.00	361,045,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,353,200.00	12,165,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,823,200.00	12,165,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,530,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	380,674,720.39	409,254,843.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	380,674,720.39	409,254,843.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	354,828,600.01	409,054,643.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,462,279.62	271,390,800.00
210101	Үндсэн цалин	103,883,257.72	143,987,873.77
210102	Нэмэгдэл	65,319,415.06	88,823,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,739,702.00	9,702,000.00
210104	Урамшуулал	26,519,904.84	28,877,126.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,948,200.00	36,502,800.00
210201	Тэтгэврийн даатгал	19,684,700.00	22,983,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,315,900.00	2,703,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,852,700.00	4,867,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	463,200.00	540,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,631,700.00	5,407,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,577,600.00	16,274,700.00
210301	Гэрэл, цахилгаан	2,894,119.11	3,462,702.98
210302	Түлш, халаалт	24,177,885.89	10,771,271.02
210303	Цэвэр, бохир ус	3,505,595.00	2,040,726.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,546,900.00	16,702,800.00
210401	Бичиг хэрэг	1,615,700.00	1,910,960.00
210402	Тээвэр, шатахуун	14,350,700.00	10,050,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,303,400.00	1,491,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	213,600.00	262,740.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,063,500.00	2,987,200.00
2105	Нормативт зардал	27,980,585.00	25,224,116.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,891,685.00	18,860,116.00
210502	Хоол, хүнс	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,088,900.00	6,364,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,525,500.00	4,348,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000.00	1,328,000.00
210604	Урсгал засвар	15,495,500.00	3,020,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,546,700.00	5,238,000.00
210702	Дотоод албан томилолт	9,546,700.00	5,238,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,764,500.00	1,067,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	224,000.00	822,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	590,000.00	45,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	52,000.00	25,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	884,800.00	167,800.00
210807	Газрын төлбөр	13,700.00	6,700.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,476,335.39	32,305,627.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	853,200.00	8,087,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,623,135.39	24,217,827.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,846,120.38	200,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	200,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	200,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,846,120.38	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,846,120.38	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	189,011,305.61	120,076,135.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	48,852,560.00	10,452,376.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	48,852,560.00	10,452,376.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(48,852,560.00)	(10,452,376.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	140,158,745.61	109,623,759.08

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	436,154,300.00	373,211,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	436,154,300.00	373,211,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	430,801,100.00	361,045,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	430,801,100.00	361,045,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,353,200.00	12,165,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,823,200.00	12,165,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,530,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	413,761,600.00	373,211,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	413,761,600.00	373,211,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	387,915,479.62	373,011,200.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,462,279.62	271,390,800.00
210101	Үндсэн цалин	103,883,257.72	143,987,873.77
210102	Нэмэгдэл	65,319,415.06	88,823,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,739,702.00	9,702,000.00
210104	Урамшуулал	26,519,904.84	28,877,126.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,948,200.00	36,502,800.00
210201	Тэтгэврийн даатгал	19,684,700.00	22,983,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,315,900.00	2,703,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,852,700.00	4,867,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	463,200.00	540,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,631,700.00	5,407,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,577,600.00	16,274,700.00
210301	Гэрэл, цахилгаан	2,894,119.11	3,462,702.98
210302	Түлш, халаалт	24,177,885.89	10,771,271.02
210303	Цэвэр, бохир ус	3,505,595.00	2,040,726.00

2104	Хангамж, бараа материалын зардал	18,705,300.00	15,380,200.00
210401	Бичиг хэрэг	1,669,700.00	1,910,960.00
210402	Тээвэр, шатахуун	13,264,000.00	9,350,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,303,400.00	1,491,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	213,600.00	262,740.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,254,600.00	2,364,600.00
2105	Нормативт зардал	78,532,200.00	13,861,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,403,300.00	12,807,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,128,900.00	1,054,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,525,500.00	5,207,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000.00	2,187,300.00
210604	Урсгал засвар	15,495,500.00	3,020,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,546,700.00	5,238,000.00
210702	Дотоод албан томилолт	9,546,700.00	5,238,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,764,500.00	1,067,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	224,000.00	822,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	590,000.00	45,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	52,000.00	25,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	884,800.00	167,800.00
210807	Газрын төлбөр	13,700.00	6,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	853,200.00	8,087,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	853,200.00	8,087,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,846,120.38	200,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	200,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	200,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,846,120.38	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,846,120.38	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	22,392,700.00	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	22,392,700.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,392,700.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	22,392,700.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,392,700.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(22,392,700.00)	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,786,273.00	216,271,737.69	20,224,907.43	451,282,918.12
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	214,786,273.00	216,271,737.69	20,224,907.43	451,282,918.12
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	214,786,273.00	216,271,737.69	20,224,907.43	451,282,918.12
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	109,623,759.08	109,623,759.08
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,786,273.00	216,271,737.69	129,848,666.51	560,906,677.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	361,064,200.00	361,045,600.00	18,600.00	99.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	361,064,200.00	361,045,600.00	18,600.00	99.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	360,845,400.00	360,845,400.00	-	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,390,800.00	271,390,800.00	-	100.00
210101	Үндсэн цалин	151,888,600.00	143,987,873.77	7,900,726.23	94.80
210102	Нэмэгдэл	88,823,800.00	88,823,800.00	-	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,702,000.00	9,702,000.00	-	100.00
210104	Урамшуулал	20,976,400.00	28,877,126.23	(7,900,726.23)	137.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,502,800.00	36,502,800.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	22,983,300.00	22,983,300.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,703,900.00	2,703,900.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,867,000.00	4,867,000.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	540,800.00	540,800.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,407,800.00	5,407,800.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,274,700.00	16,274,700.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	4,185,600.00	3,462,702.98	722,897.02	82.73
210302	Түлш, халаалт	10,532,000.00	10,771,271.02	(239,271.02)	102.27
210303	Цэвэр, бохир ус	1,557,100.00	2,040,726.00	(483,626.00)	131.06
2104	Хангамж, бараа материалын зардал	15,130,200.00	15,130,200.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	2,318,400.00	1,660,960.00	657,440.00	71.64
210402	Тээвэр, шатахуун	8,314,800.00	9,350,000.00	(1,035,200.00)	112.45
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	919,500.00	1,491,900.00	(572,400.00)	162.25
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	520,900.00	262,740.00	258,160.00	50.44
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,056,600.00	2,364,600.00	692,000.00	77.36
2105	Нормативт зардал	10,033,800.00	10,033,800.00	-	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,979,800.00	8,979,800.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,054,000.00	1,054,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,207,300.00	5,207,300.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,187,300.00	2,187,300.00	-	100.00
210604	Урсгал засвар	3,020,000.00	3,020,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	5,238,000.00	5,238,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	5,238,000.00	5,238,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,067,800.00	1,067,800.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	822,700.00	822,700.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45,100.00	45,100.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,500.00	25,500.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	167,800.00	167,800.00	-	100.00
210807	Газрын төлбөр	6,700.00	6,700.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	218,800.00	200,200.00	18,600.00	91.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	218,800.00	200,200.00	18,600.00	91.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	218,800.00	200,200.00	18,600.00	91.50
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	361,064,200.00	361,045,600.00	18,600.00	99.99
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	361,064,200.00	361,045,600.00	18,600.00	99.99
131001	Улсын төсвөөс санхүүжих	361,064,200.00	361,045,600.00	18,600.00	99.99
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	14.00	14.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	12,165,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	12,165,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	12,165,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	250,000.00
210401	Бичиг хэрэг	-	250,000.00
2105	Нормативт зардал	-	3,828,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	3,828,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,087,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,087,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	12,165,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	12,165,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,165,800.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь “Бүсийн хэмжээнд зоонозын халдварт өвчнүүдийг тандах, хянах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

- *Байгалийн голомтод халдварт өвчин болон Зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх,*
- *Тархалтыг судлах, уг өвчинтэй тэмцэх ажлыг зохион байгуулах,*
- *Мэргэжлийн тусламж үйлчилгээ, үзүүлэх*

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус төвийн санхүүгийн үйл ажиллагаанд Зоонозын үндэсний төвийн дотоод хяналтын багаас хяналт, шалгалт хийгддэг бөгөөд төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төв нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/17 дугаар тушаалаар байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Уг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн 2017 оноос хойш “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-д 2019-2022 онуудад нийт 5 удаа нэмэлт өөрчлөлт орж шинэчилсэн найруулга хийгдсэн, “Зардлын эдийн засгийн ангилал”, УСНББОУС, СТОУС нь 2021 онд шинэчлэгдсэн зэрэг тодорхой хэмжээний нэмэлт өөрчлөлт орсон тул эдгээр өөрчлөлтүүдэд нийцүүлэн бодлогын бичиг баримтыг шинэчлэн боловсруулах нь зүйтэй юм.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөөт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 109,623.7 мянган төгрөгөөр буюу 19.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	144,606.6	122,328.6	(22,278.0)
Үндсэн хөрөнгө	306,676.3	438,578.0	131,901.7
Нийт хөрөнгө	451,282.9	560,906.7	109,623.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	451,282.9	560,906.7	109,623.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	451,282.9	560,906.7	109,623.7

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Бараа материал дансны үлдэгдэл 122,328.6 мянган төгрөг болж 22,278.0 мянган төгрөгөөр буурсан нь 62,060.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 438,578.0 мянган төгрөг болж 131,901.7 мянган төгрөгөөр өссөн нь 156,119.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж /автоклав –

эмнэлгийн хог хаягдал устгах/-ийг ЭМЯ-наас төлбөргүйгээр хүлээн авснаас тус тус шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төв нь 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 509,222.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлсийг 90,081.6 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 7,149.8 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 10,426.2 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,755.2 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 20,415.0 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 3,330.0 мянган төгрөгөөр зэрэг нийт 148,157.8 мянган төгрөгөөр бууруулан, 361,064.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 361,064.2 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөж, олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 361,056.6 мянган төгрөг буюу 99.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	360,845.4	360,845.4	-	100
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	218.8	200.2	18.6	91.5
	Нийт	361,064.2	361,056.6	18.6	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус төвийн нэмэлт санхүүжилтийн дансанд нийт **12,165.8** мянган төгрөгийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2023 оны А/194 дүгээр захирамжийн дагуу “Хилийн бүсийн нутаг дэвсгэр дэх хачигт халдварын оношилгоо” сэдэвт Олон Улсын сургалт зөвлөгөөний зардалд 9,900.0 мянган төгрөгийг,
- Аймгийн Засаг даргын 2023 оны А/347 дугаар захирамжийн дагуу аймгийн баяр наадам болохтой холбогдуулан цэнгэлдэх хүрээлэнгийн ариутгал халдваргүйтгэлийн зардалд 823.2 мянган төгрөгийг,
- Аймгийн Засаг Даргын 2023 оны А/440 дүгээр захирамжийн дагуу үерийн усны гамшгийн үеийн ариутгал халдваргүйтгэлийн зардалд 1,442.0 мянган төгрөгийг тус тус зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн анхан шатны баримтын бүрдүүлэлт, хөрөнгийн ангилалтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 409,254.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,092.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус төв нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, кино контент, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллээс 1 мэдээллийг огт мэдээлээгүй бол 18 мэдээг буруу мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

1. Огт мэдээлээгүй:
 - Төсөвт байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл- хөтөлбөр, зориулалтын мэдээлэл
2. Буруу мэдээлсэн:
 - Дараа жилийн төсвийн төсөл
 - Байгууллагын батлагдсан төсөв
 - Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийг шалтгаа тайлбарын хамт- эдийн засгийн ангиллаар– 8 удаа
 - Төсөвт байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл- хөтөлбөр, зориулалтын мэдээлэл– 8 удаа,
3. Хугацаа хоцроосон:
 - Төсөвт байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл- хөтөлбөр, зориулалтын мэдээлэл,
 - Санхүүгийн тайлан /хагас жил/
 - Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй,бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн нягтлан бодогч М.Сэлэнгэд **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус ангийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 12,119.7 мянган төгрөгийн худалдан авалтыг баримтаар баталгаажуулаагүй, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон зэрэг 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, төрийн албан хаагчийн урамшуулал давхардуулан олгосон, ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнээгүй олгосон зөрчлүүдэд зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 75.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	3,630.0	1	3,630.0	100
	1	-	-	-	-
Зөвлөмж	1	1,664.7	1	1,664.7	100
	1	6,825.0	1	6,825.0	100
Нийт дүн	4	12,119.7	3	12,119.7	75.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Ковид 19 цар тахал өвчинтэй холбоотойгоор өмнөх онуудад ЭМЯ, аймгийн ЭМГ-аас үнэ төлбөргүй шилжүүлсэн болон байгууллагын төсвийн хөрөнгөөр худалдан авсан нийт 101,086.9 мянган төгрөгийн 40,580 ширхэг нэг удаагийн хамгаалах хэрэгсэл /био аюулгүйн сав, бээлий, маск, нүдний шил, аюулгүйн хайрцаг, комбинезон, хормогч/ нь тус төвийн бараа материалын дансанд бүртгэлтэй байна. Эдгээр бараа материалын ашиглалтын хугацаа дуусах, хадгалалтын нөхцөл алдагдах эрсдэлтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар үндсэн хөрөнгийн шинж чанартай тог баригч, сандал, камер, микроскоп зэрэг нийт **7,805.6** мянган төгрөгийн өртөг бүхий 9 хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн алдаа¹ илэрсэн байна.

Энэ нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д “Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд залруулах зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 41,548.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 1,667.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 39,881.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт.

1.1 Илрүүлэлт: М.Сэлэнгэ, Г.Отгонсүрэн, Д.Туул нарт төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг төрд ажилласан жилээс зөрүүтэй тооцоолж, нийт 1,467.1 мянган төгрөг илүү олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад 2 дахь “Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад **ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас ... хувиар бодож олгоно**” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2.1 Илрүүлэлт: Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас нягтлан бодогч М.Сэлэнгэд олгосон 200.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг дутуу суутгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.2 Шийдвэрлэсэн нь: Дутуу суутгасан цалингийн урьдчилгааг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал:**

1.1 Илрүүлэлт: Тайлант онд зарцуулсан нийт 36,091.1 мянган төгрөгийн бараа материалыг тухай бүр бичсэн шаардах хуудсаар бус сар бүрийн эцэст бөөн дүнгээр зарлагадсан бол 3,789.9 мянган төгрөгийн материалыг бөөн дүнгээр орлого авсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасныг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Бараа материалын хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр баримтжуулан бүртгэж байх.

2.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0” болсон 52 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байна. Энэ нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д “Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм” ХЗУ4-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг ашиглах бол дахин үнэлэх буюу акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хрөнгө ангилал буруу бүртгэсэн.	1	7,805.6			1	7,805.6			1	7,805.6	1	7,805.6
Дүн	1	7,805.6			1	7,805.6			1	7,805.6	1	7,805.6

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТАХХ-ны нэмэгдэл илүү тооцож олгосон	1	1,467.1	1	1,467.1								
Урьдчилгаа суутгаагүй	1	200.0	1	200.0								
БМ-ын хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр бүртгээгүй	1	39,881.0					1	39,881.0				
Хөрөнгийн үнэлгээг хийгээгүй	1	-					1	-				
Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан	1								1	1		
Дүн	5	41,548.1	2	1,667.1			2	39,881.0	1	1		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Зөвлөмж	
							Тоо	Дүн		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож болон огт мэдээлээгүй, буруу мэдээлсэн	24	-					24	-		
Нийт дүн	24	-					24	-		